“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ
БАГАНУУР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖИЙН
12 ДУГААР САРЫН БИЕЛЭЛТ

2020 оны 12 дугаар сарын 30 Багануур дүүрэг

| № | Ирсэн огноо | Батлагдсан огноо | Дугаар | Биелэлт |
|---|---|---|---|---|
| 1 | 2020.12.12 | 2020.12.12 | А/401 | - Газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн А/38 дугаар тушаалаар тогтоосон хугацаанд байгууллагын үйл ажиллагааны цагийг хэвийн горимоор буюу 08:30-17:30 цагаар тогтоосон.<br>- Цахимаар ажиллаж байгаа 4 ажилчид ERP системээр цагийг бүртгүүлж байна.<br>- Бусад ажилчид ажил эхэлсэн өдрөөс цагийг цаг бүртгэлийн төхөөрөмжнөөс бүртгүүлж, халдвар хамгааллын дэглэмийг баримтлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>- Дээрх тушаалын 2 дугаар хавсралтаар ХАБЭА, Халдвар хамгааллын төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>- 12 дугаар сарын 13-ны өдөр даргын зөвлөлийн хурлыг цахимаар зохион байгуулж, 14-ний өдөр ариутгал, халдваргүйтгэлийг “Их хурай” ХХК-аар хийлгэсэн.<br>- Ажилтнуудыг ажлын байранд нэвтрэхээс өмнө биеийн халууныг хэмжиж амны хаалт зүүлгэн, гарыг халдваргүйжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.<br>- Ажлын байрны цэвэрлэгээг тогтмол хийх, хүний гар хүрэх газрыг 2 цаг тутамд ариутгах, ажлын байрыг өдөр бүр агааржуулах, 7 хоногт нэг удаа их цэвэрлэгээ хийх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.<br>- Иргэдийн зорчих хөдөлгөөний мэдээллийг бүртгэх QR кодыг зааврын дагуу хэвлэн иргэдийн орох хэсэгт ил харагдахаар байршуулсан.<br>- Уг заалтын хэрэгжилтийг хангах, ажилтнуудын ажил үүргийг бүрэн гүйцэтгүүлэх, цаг ашиглалтын зөв төлөвлөлтөд Захиргааны болон Үйлдвэрлэл, технологийн албаны Ахлах мэргэжилтнүүд хяналт тавин ажиллаж байна.<br>УОК-ын үүрэг чиглэлийн дагуу 2020.12.23-ны өдрөөс Нийслэлд бүх нийтийн бэлэн байдлын зэрэглэлийг хэсэгчилсэн байдлаар тогтоож байгаатай холбогдуулан ДЗХ-аар хэлэлцэж, Газрын дарга, бичиг хэрэг, архив, гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн болон Үйлдвэрлэл технологийн албаны Ахлах мэргэжилтэн нийт 3 ажилтанг ажлын байранд, 9 ажилтанг цахимаар ажиллуулахаар байгууллагын дотоод зохион байгуулалтыг хийсэн. |

ХЯНАСАН:
“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК”
ОНӨТҮГ-ЫН ДАРГА Ч.ЭЛБЭГСАЙХАН

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
ЗАХИРГААНЫ АЛБАНЫ
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Э. ЭНХЗАЯА